



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 461

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай**

“Монгол шуудан” хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 33, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж 102.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Монгол шуудан” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Анхбаатарт дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах;

2.2. Анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг баримталж, төлбөрийн баримтыг цахим хэлбэрээр авч байх;

2.3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000949

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 10 дүгээр сарын 29 ний өдрийн
 №1 дугаар тогтоолын хавсралт

“Монгол шуудан” хувьцаат компанийн компанийн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
 арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Зөрчлийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 33, 48 дугаар зүйлд, заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ажиллагсад, холбогдох үнэлгээний хорооны гишүүд	102.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлаж, журмын дагуу зохион байгуулж, тогтоосон хугацаанд тайлан гаргах. Зөрчил, дутагдлыг арилгасан талаарх биелэлтийг ирүүлэх.
Зөрчил, дутагдлын нийт дүн			102.7	

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН УДИРДЛАГА, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг зүйл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан 2019 оны хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн даргын баталсан удирдамжийг удирдлага болгон “Монгол шуудан” ХК-ийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийлээ.

Шалгалтаар тус компанийн газрын санхүү, эдийн засаг, үйлдвэрлэл, үр ашгийн байдал, төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хөрөнгөд бүртгэлээр тавьж буй хяналт, захиралтай байгуулсан гэрээ болон “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-гээр хүлээсэн үүргийн хэрэгжилт явц, өр авлага түүний барагдуулалт, тооцоо нийлсэн акт, байгууллага аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ хэлцэл, худалдан авалтын үйл ажиллагаа зэргийг шалгаж, дүгнэлт гаргав.

Шалгалтанд хамрагдах хугацааны санхүүгийн баримтанд 1 дүгээр гарын үсгийг захирал Б.Анхбаатар, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Б.Наранцэцэг нар зурж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Хүснэгт. № 1.1.

№	Гүйцэтгэх захирлын нэр	Томилогдсон, чөлөөгдсөн огноо	Ерөнхий нягтлан бодогчийн нэр	Томилогдсон, чөлөөгдсөн огноо
1	Б.Анхбаатар	2016.10.06	Б.Наранцэцэг	2016.11.01

Хоёр. Товч танилцуулга, үндсэн үйл ажиллагаа

Монгол шуудан ХК анх 1921 оны 07 дугаар сарын 19-ний өдөр Ардын ЗГ-ын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор МУ-ын шуудан бичиг, Цахилгаан мэдээний ерөнхий хороо нэртэйгээр байгуулагдсан. Энэ цагаас хойш хөгжлийн үе шатуудад Төв шуудан тасаг, Төв шуудан, Шуудан холбооны газар, Монгол шуудан ТӨҮГ, Монгол шуудан ХХК, Монгол шуудан ТӨХК болон хөгжиж ирсэн бол Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70-р тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 330-р тогтоол, Төрийн өмчийн хорооны 594-р тогтоолын дагуу компанийн нийт хувьцааны 34%-ийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан борлуулж 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс нээлттэй хувьцаат компаний болон үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь Монгол Улсын шуудангийн салбарын анхдагч байгууллагын хувьд Шуудангийн үндсэн эзэмших “А” ангилалын лиценз, Олон улсын буухиа шуудангийн үйлчилгээ үзүүлэх, Улс хоорондын логистик тээврийн үйлчилгээ үзүүлэх, Улс хоорондын шуудангийн үйлчилгээний сүлжээ байгуулах зэрэг тусгай зөвшөөрлийн хүрээнд шуудангийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлж байна.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Шуудангийн үндсэн үйлчилгээ: Бичиг захидал, боодол, илгээлт, буухиа шуудан зэрэг шуудангийн үндсэн нэр төрлийн үйлчилгээг улс хооронд болон дотоодын зах зээлд хүргэж гардуулах
- Шуудангийн логистик, транзитийн үйлчилгээ: Хот хоорондын логистик үйлчилгээ, Улс хоорондын логистик тээврийн үйлчилгээ, Улс хоорондын транзит үйлчилгээг өөрийн болон гэрээт тээвэрлэгчээр тээвэрлүүлж, бүх төрлийн тээвэр зууч логистикийн үйлчилгээг үзүүлж байна.
- Шуудангийн санхүүгийн үйлчилгээ: Даатгалын үйлчилгээ, агентийн үйлчилгээ, хөрөнгийн түрээс, ашиглалтийн үйлчилгээг шуудангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд нийцүүлэн үзүүлж байна.
- Шуудангийн үнэт цаас, маркын үйлдвэрлэлт, борлуулалт: Шуудангийн зориулалт бүхий маркыг Монгол улсын засгийн газраас батлагдсан сэдвийн төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэн борлуулдаг ба Шуудангийн мэндчилгээ, ил захидал, бүх төрлийн дугтуй, маягтын үйлдвэрлэлийг эрхлэн борлуулж байна.
- Шуудангийн нэмэлт үйлчилгээ: Шуудангийн салбаруудын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, сүлжээний алдагдлыг бууруулах зорилгоор гадаад, дотоод хэвлэл захиалга, хүргэлтийн үйлчилгээ, захиалгат болон гэрээт бараа бүтээгдэхүүн борлуулах зэрэг бусад нэмэлт үйлчилгээг салбар нэгжүүдээр дамжуулан үзүүлж байна.

2.1. Компанийн бүтэц зохион байгуулалт:

Тус компанийн бүтэц зохион байгуулалтын хувьд 5 газар, 4 хэлтэс, 3 алба, Улаанбаатар хотын 40 салбар, аймгийн төвийн 21 салбар, 334 сум суурингийн салбарт нийт 921 ажилтантайгаар үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хүснэгт. № 2.1. Удирдлагын жагсаалт:

№	Нэр	Албан тушаал	Томилогдсон огноо
1	Г.Тэлмэн	Бизнес, төлөвлөлт хариуцсан дэд захирал	2016.11.08
2	Ш.Наранбат	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	
3	Б.Наранцэцэг	Нягтлан бодох, бүртгэлийн газрын захирал бөгөөд ерөнхий нягтлан бодогч	2016.11.01
4	Д.Төмөрбаатар	Захиргаа, хүний нөөцийн газрын захирал	2016.11.10
5	Д.Баттулга	Бизнес хөгжлийн газрын захирал	2016.11.18
6	Б.Содчимэг	Шуудан технологийн газрын захирал	2016.12.02
7	Н.Хосбаяр	Тээвэр зууч, логистикийн газрын захирал	2016.12.06
8	Б.Цэнд-Аюуш	Хууль эрх зүй, худалдан авах ажиллагааны газрын захирал	2018.04.03
9	А.Эрхэмбаяр	Бизнес хөгжлийн газрын захирал	2019.02.13


2.2. Хувьцааны ханш ба зах зээлийн үнэлгээ:

Тус компанийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй болж, орлого ашгийн хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор компанийн зах зээлийн үнэлгээ 21.1 тэрбум ₮-с 68.1 тэрбум ₮ т хүрч өссөн байна.

Хүснэгт. 2.2. Хувьцааны ханш: /Төгрөгөөр/

№	Огноо	Хувьцааны ханш	Хувьцааны тоо	Зах зээлийн үнэлгээ
1	2016.01.20	212.12	99,586,363	21,124,259,319.56
2	2018.12.31	684.03	99,586,363	68,120,059,882.89

2.3. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц:



Нийт хувьцааны 66 хувийг төр эзэмшиж, 25.2 хувийг Ард санхүүгийн нэгдэл, 8.8 хувийг бусад жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг байна. “Монгол Шуудан” ХК-ийн хувьцаа нь Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн I ангилалд багтаж байна.

Хүснэгт: № 2.3. Орлого, ашиг: /Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он
1	Орлого /сая.төг/	11,923.1	13,672.6	15,474.0
2	Цэвэр ашиг /сая.төг/	1,006.6	1,224.2	1,560.3

2.4. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрээр батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Шуудангийн ялган боловсруулах төв байгуулах, түүнтэй холбоотой тоног төхөөрөмж, програм хангамжийн төслүүд 2019 оноос хэрэгжиж байна. Мөн салбарын байр худалдан авах үйл ажиллагаа 2019-2020 онд шат дараатайгаар хэрэгжих төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Хүснэгт: № 2.4. Хөрөнгө оруулалтын зарцуулалт: /Төгрөгөөр/

№	Зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Шуудангийн логистик төв	3,700,000,000.00		Барилга баригдаж байгаа
2	Тоног төхөөрөмж, программ хангамж	761,000,000.00		Хүлээгдэж байгаа
3	Салбарын барилга худалдан авах	1,000,000,000.00	313,000,000.00	Хийгдэж дууссан
4	Ребрендинг	367,000,000.00	360,200,000.00	Хийгдэж дууссан
5	Автопарк шинэчлэл (10 машин)	350,000,000.00	274,000,000.00	Хийгдэж дууссан
	Нийт	6,178,000,000.00	947,200,000.00	

Гурав. 2017-2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа, зорилтот түвшингийн төлөвлөгөөний биелэлт:

Хүснэгт: № 3.1. Зорилтот түвшин /Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ХН	2017 он		Харь/хувь	2018 он		Харь/хувь
			Төл/гөө	Гүйц		Төл/гөө	Гүйц	
1	Нийт орлого	Сая.төг	13,070.0	13,672.6	104.6	14,390.0	15,474.0	107.5
2	Нийт зардал	Сая.төг	12,355.0	12,321.0	99.7	13,710.0	13,731.5	100.2
3	Татварын өмнөх ашиг	Сая.төг	715	1,351.6	189	680	1,742.4	256.2

4	Орлогын татварын зардал	Сая.төг	71.5	127.4	178.2	68	182.2	267.9
5	Цэвэр ашиг	Сая.төг	643.5	1,224.1	190.2	612	1,560.3	254.9
6	Нийт ажиллагсад	Хүн	920	916	99.6	916	917	100.1
7	Цалингийн сан	Сая.төг	6,400.0	6,419.7	100.3	6,840.0	6,845.3	100.1
8	Нийт авлага	Сая.төг	3,000.0	3,533.4	117.8	3,000.0	6,168.1	205.6
9	Нийт өр төлбөр	Сая.төг	2,000.0	19,435.1	971.8	5,000.0	11,498.4	230
10	Нийт хөрөнгө оруулалт	Сая.төг	-	2,488.4		7,882.5	1,811.5	23
	Үүнээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр	Сая.төг	-	-		5,600.0	-	-
11	Ногдол ашиг	Сая.төг	-	367.2		180	468.1	260
12	Элэгдлийн зардал	Сая.төг	650	768.6	118.3	800	864.3	108

3.1. Орлого, зардал, үр ашгийн талаар

2017 онд нийт 13,672.6 сая нийт төгрөгийн орлого олж, 12,321.0 сая төгрөгийн зардал гаргаж, 1,224.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 104.6 хувиар, зардлын төлөвлөгөөг 99.7 хувиар, цэвэр ашгийн төлөвлөгөөг 190.2 хувиар тус тус биелүүлж ажилласан байна.

2018 онд нийт 15,474.0 сая нийт төгрөгийн орлого олж, 13,731.5 сая төгрөгийн зардал гаргаж, 1,560.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 107.5 хувиар, зардлын төлөвлөгөөг 100.2 хувиар, цэвэр ашгийн төлөвлөгөөг 254.9 хувиар тус тус биелүүлж ажилласан байна.

Хүснэгт: № 3.2. Орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл /Сая төгрөгөөр/

№	Дансны нэр	2017 он			2018 он		
		Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү
1	Бодлын орлого	250.0	274.5	24.5	290.0	316.9	26.9
2	Зээл албан бичгийн орлого	1,100.0	1,264.2	164.2	1,280.0	921.2	-358.8
3	Баталгааны орлого	150.0	214.1	64.1	200.0	493.1	293.1
4	Илгээлтийн орлого	1,200.0	1,122.7	-77.3	1,250.0	1,376.9	126.9
5	Буухианы орлого	1,000.0	1,026.8	26.8	1,150.0	1,125.5	-24.5
6	Шуудангийн хайрцагны орлого	130.0	113.4	-16.6	130.0	104.2	-25.8
7	Хүргэлтийн орлого	1,400.0	666.4	-733.6	1,250.0	1,141.9	-108.1
8	Гардуулалтын карт	50.0	48.9	-1.1	50.0	49.8	-0.2
9	Илгээмжийн барааны цэвэр орлого	150.0	248.4	98.4	350.0	347.2	-2.8
10	Гэрээт бараа борлуулсны шимтгэл	50.0	34.5	-15.5	-	36.9	36.9
11	Зорчигчийн орлого	200.0	168.2	-31.8	180.0	130.6	-49.4
12	Директ шуудан	25.0	-	-25.0	20.0	-	-20.0
13	Маркны орлого	700.0	677.0	-23.0	730.0	674.3	-55.7
14	Үнэт цаасны борлуулалт	300.0	306.3	6.3	350.0	371.5	21.5
15	Хэвлэлийн шимтгэлийн орлого	300.0	472.8	172.8	600.0	256.0	-344.0
16	Хэвлэлийн хүргэлтийн орлого /жингийн/	300.0	332.2	32.2	300.0	322.3	22.3
17	Улс хоорондын тооцооны орлого	2,350.0	2,253.5	-96.5	2,350.0	2,358.8	8.8
18	Даатгалын үйлчилгээний орлого	10.0	7.0	-3.0	20.0	8.5	-11.5
19	Байр түрээслүүлсний орлого	100.0	101.3	1.3	120.0	108.0	-12.0
20	Логистик үйлчилгээний орлого	400.0	435.1	35.1	1,200.0	745.3	-454.7
21	Бусад нэмэлт үйлчилгээний орлого	150.0	315.9	165.9	-	166.8	166.8
22	Үйл ажиллагааны орлого	600.0	1,450.6	850.6	450.0	978.5	528.5

23	Транзит шуудангийн орлого	1,800.0	1,531.0	-269.0	1,600.0	3,480.1	1880.1
24	Хэвлэх үйлдвэрийн орлого	-	-	-	20.0	-	-20.0
25	БНҮҮС	200.0	178.0	-22.0	200.0	-	-200.0
26	Бусад	155.0	14.3	-140.7	300.0	0.9	-299.1
27	Ханшийн зөрүү	-	448.8	448.8	-	-	0.0
Нийт орлого		13,070.0	13,705.8	635.8	14,390.0	15,515.2	1,125.2
28	Борлуулалтын хөнгөлөлт буцаалт	-	33.2	33.2	-	41.2	41.2
29	Цэвэр орлого	13,070.0	13,672.6	602.6	14,390.0	15,474.0	1,084.0

3.2. Зардлын задаргаа, хэтрэлт хэмнэлт:

Хүснэгт: № 3.3. Зардлын төлөвлөгөөний гүйцэтгэл /Сая төгрөгөөр/

№	Дансны нэр	2017 он			2018 он		
		Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	5,750.0	5,281.0	-469.0	6,100.0	6,113.2	13.2
2	НДШ/ЭМД	650.0	603.8	-46.2	740.0	732.1	-7.9
3	Томилолт	110.0	63.9	-46.1	100.0	108.0	8.0
4	Уур ус халаалт	210.0	170.8	-39.2	200.0	175.2	-24.8
5	Гэрэл цахилгаан	60.0	49.8	-10.2	50.0	58.2	8.2
6	Түрээсийн зардал	250.0	240.7	-9.3	250.0	282.6	32.6
7	Шуудан, мэдээлэл, холбоо	295.0	231.1	-63.9	300.0	222.4	-77.6
8	Үндсэн ба туслах материал	45.0	128.8	83.8	100.0	157.8	57.8
9	ҮХЭХШимтгэл	650.0	768.6	118.6	800.0	864.3	64.3
10	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	250.0	235.3	-14.7	250.0	256.2	6.2
11	Хөд/хамгаалал ариун цэвэр	75.0	10.3	-64.7	50.0	24.1	-25.9
12	Бичиг хэрэг, хангамж	120.0	51.1	-68.9	70.0	60.3	-9.7
14	Тээврийн зардал	665.0	966.6	301.6	1370.0	1848.1	478.1
15	Шатахуун	700.0	507.3	-192.7	500.0	492.1	-7.9
16	Сэлбэг	130.0	78.1	-51.9	110.0	87.5	-22.5
17	Харуул хамгаалалт, гал команд	40.0	18.8	-21.2	40.0	32.5	-7.5
18	Зар сурталчилгаа	100.0	81.7	-18.3	150.0	90.2	-59.8
19	Тэтгэвэр тэтгэмж	140.0	127.8	-12.2	100.0	98.4	-1.6
20	Ахмадын зардал	40.0	29.4	-10.6	40.0	34.4	-5.6
21	Сургалт	35.0	45.3	10.3	60.0	36.2	-23.8
22	Ёслолын зардал	95.0	116.0	21.0	130.0	135.3	5.3
23	Татвар, даатгал	78.0	82.4	4.4	100.0	73.0	-27.0
28	Банкны үйлч/зардал	8.0	15.0	7.0	20.0	20.7	0.7
30	Засвар үйлчилгээ	74.0	25.4	-48.6	120.0	39.9	-80.1
31	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	50.0	75.4	25.4	100.0	106.0	6.0
32	Шагнал урамшуулал	15.0	21.9	6.9	30.0	28.8	-1.2
33	ҮҮА-ны бусад зардал	100.0	50.8	-49.2	50.0	97.0	47.0
34	Гадаад шуудангийн зардал	700.0	1,099.0	399.0	780.0	939.5	159.5
35	Үйл ажиллагааны бус зардал	0.0	23.9	23.9	0.0	23.9	23.9
36	Удирдлага	820.0	700.7	-119.3	850.0	885.8	35.8
37	Ханшийн зөрүүний алдагдал	0.0	19.4	19.4	0.0	0.0	0.0
38	Бусад алдагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
39	Нийгмийн асуудал	100.0	100.0	0.0	150.0	100.0	-50.0
Нийт зардал		12,355.0	12,020.4	-334.6	13,710.0	14,223.8	513.8

Зардлыг нэр төрлөөр нь авч үзвэл зарим нэр төрлийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс хэмнэсэн боловч зарим зардлыг хэтрүүлж зарцуулсан байгааг анхаарч, төлөвлөгөөнөөс зардлыг хэтрүүлэхгүй байх шаардлагатай байна.

3.3. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн талаар

Касс дахь бэлэн мөнгө 2017 оны жилийн эхэнд 1.3 сая төгрөг, 2017 оны жилийн эцсээр 6.5 сая төгрөг, 2018 оны жилийн эцсээр 15.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан байна. Банкан дахь харилцах дасанд 2017 оны жилийн эхэнд 8,680.0 сая төгрөг, 2017 оны жилийн эцсээр 26,652.8 сая төгрөг, 2018 оны жилийн эцсээр 17,251.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан байна.

Хүснэгт: № 3.4. /Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31	2018.12.31
1	Касс дахь мөнгө	1,382.7	6,543.5	15,670.6
2	Банкан дахь мөнгө	8,680,028.2	26,652,772.7	17,251,412.5
Нийт дүн		8,681,410.9	26,659,316.2	17,267,083.1

3.4. Авлагын талаар

Авлага 2017 оны эхэнд 3,314.2 сая төгрөг, оны эцэст 3,341.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеээс 27.6 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн. Авлага 2018 оны эхэнд 3,341.8 сая төгрөг, оны эцэст 6,266.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеээс 2,924.6 сая төгрөгөөр буюу 46.7 хувиар өссөн байна.

Хүснэгт: № 3.5. /Мянган төгрөгөөр/

№	Авлагын ангилал	2017.01.01	2017.12.31	2018.12.31
1	Дансны авлага	3,229,148.2	2,890,009.5	5,886,427.9
2	Татварын авлага	0.0	316.1	11,214.6
3	Бусад авлага	85,066.4	451,498.7	368,786.9
ДҮН		3,314,214.6	3,341,824.3	6,266,429.4

Цаашид холбогдох авлагын асуудлыг шуурхай барагдуулах арга хэмжээ авч, харилцагчтай тооцоо нийлж, хугацаа хэтэрч найдваргүй болсон болон нөөц сан бүрдүүлсэн авлагыг барагдуулах талаар хууль, хяналтын байгууллагад хандан шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

3.5. Бусад санхүүгийн хөрөнгө

Бусад санхүүгийн хөрөнгө 2017 оны эхэнд 6,100.0 сая төгрөг байсан бол оны 350.0 сая төгрөг босон байна. 2018 оны эхэнд 350.0 сая төгрөг байсан бол оны эцэст үлдэгдэлгүй болсон байна. Үүнд:

Хүснэгт: № 3.6. /Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31	2018.12.31
1	Засгийн газрын бонд	6,100,000.0	350,000.0	0.0
ДҮН		6,100,000.0	350,000.0	0.0

3.6. Өглөгийн талаар

Богино хугацаат өр төлбөр 2017 оны эхэнд 7,225.0 төгрөг байсан бол эцэст 18,575.5 сая төгрөг болж өмнөх оноос 11,350.5 сая төгрөгөөр буюу 61.1 хувиар өссөн байна. Богино хугацаат өр төлбөр 2018 оны эхэнд 18,575.5 сая төгрөг байсан бол эцэст 10,508.8 сая төгрөг болж өмнөх оноос 8,066.6 сая төгрөгөөр буюу 76.8 хувиар буурсан байна. Үүнд:

Хүснэгт: № 3.7. Богино хугацаат өглөг /Мянган төгрөгөөр/

№	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2017.01.01	2017.12.31	2018.12.31
1	Дансны өглөг	6,995,178.3	18,315,301.6	10,213,019.9
2	Татварын өр	79,283.2	116,473.2	69,130.8
3	Бусад богино хугацаат өр төлбөр	150,580.6	143,725.8	226,701.9
Богино хугацаат өр төлбөрийн дүн		7,225,042.1	18,575,500.6	10,508,852.6

Урт хугацаат өр төлбөр, зээл 2017-2018 онд үүсээгүй байна.

3.7. Бараа материалын талаар

2017 оны эхэнд 1,668.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бол 2017 оны эцэст 1,723.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, үлдэгдэл 55.0 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар өсчээ. 2018 оны эхэнд 1,723.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бол 2018 оны эцэст 2,095.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, үлдэгдэл 372.1 сая төгрөгөөр буюу 21.6 хувиар өсчээ.

Хүснэгт: № 3.8. Бараа материал /Мянган төгрөгөөр/

№	Бараа материалын төрөл	2017.01.01	2017.12.31	2018.12.31
1	Түүхий эд материал	46,751.3	30,052.1	23,406.0
2	Дуусаагүй үйлдвэрлэл	13,303.7	17,199.2	20,033.2
3	Бэлэн бүтээгдэхүүн	721,411.8	735,274.6	788,946.0
4	Бараа	0.0	0.0	0.0
5	Хангамжийн материал	379,773.4	372,774.4	641,385.1
6	Бусад	506,850.5	567,745.9	621,345.7
Нийт дүн		1,668,090.7	1,723,046.2	2,095,116.0

3.8. Үндсэн хөрөнгийн талаар

2017 оны эхэнд 11,762.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол 894.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 374.9 үндсэн хөрөнгө хасагдаж, оны эцэст 12,281.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болж, 4,115.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 8,165.8 сая төгрөгийн дансны цэвэр үндсэн хөрөнгөтэй болсон байна.

Хүснэгт: № 3.9. 2017 оны үндсэн хөрөнгө /Мянган төгрөгөөр/

Дансны нэр	2017.01.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2017.12.31
Газрын сайжруулалт				
Барилга байгууламж	5,913,864.0	508,666.2	2,848.3	6,419,681.9
Машин, тоног	1,278,435.9	72,086.6	27,297.1	1,323,225.4
Тээврийн хэрэгсэл	3,490,887.6	22,035.0	187,938.2	3,324,984.4
Тавилга эд хогшил	686,076.4	85,156.4	91,270.7	679,962.1
Компьютер, бусад хэрэгсэл	0.0	0.0	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	392,715.7	206,527.5	65,560.5	533,682.7
Нийт дүн	11,761,979.6	894,471.7	374,914.8	12,281,536.5
Хуримтлагдсан элэгдэл	3,717,066.4	826,838.9	428,173.1	4,115,732.2
Дансны цэвэр дүн	8,044,913.2			8,165,804.3

2018 оны эхэнд 12,281.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол 788.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 268.9 үндсэн хөрөнгө хасагдаж, оны эцэст 12,800.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болж, 4,732.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 8,068.3 сая төгрөгийн дансны цэвэр үндсэн хөрөнгөтэй болсон байна.

Хүснэгт: № 3.10. 2018 оны үндсэн хөрөнгө /Мянган төгрөгөөр/

Дансны нэр	2018.01.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2018.12.31
Газрын сайжруулалт				
Барилга байгууламж	6,419,681.9	159,133.4	8,500.0	6,570,315.3
Машин, тоног	1,323,225.4	81,574.6	24,200.8	1,380,599.2
Тээврийн хэрэгсэл	3,324,984.4	354,485.0	157,466.3	3,522,003.1
Тавилга эд хогшил	679,962.1	168,758.9	51,171.9	797,549.1
Компьютер, бусад хэрэгсэл	0.0	0.0	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	533,682.7	24,276.7	27,539.8	530,419.6
Нийт дүн	12,281,536.5	788,228.6	268,878.8	12,800,886.3
Хуримтлагдсан элэгдэл	4,115,732.2	925,408.6	308,564.6	4,732,576.2
Дансны цэвэр дүн	8,165,804.3			8,068,310.1

3.9. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн талаар

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 2017 оны эхэнд 3,379.9 сая төгрөг оны эцэст 3,379.9 сая төгрөг, 2018 оны эцэст 3,379.9 сая төгрөг байна.

Хүснэгт: № 3.11. 2017 оны үндсэн хөрөнгө /Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31	2018.12.31
1	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919.5	3,379,919.5	3,379,919.5
2	Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл			
	Нийт дүн	3,379,919.5	3,379,919.5	3,379,919.5

Дөрөв. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын тухайд

4.1 Худалдан авах ажиллагааны зөрчлийн талаар

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу “Монгол шуудан” ХК нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа энэ хуулийг мөрдөх үүрэгтэй.

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт:

Захиалагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасны дагуу 2017, 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт:

“Монгол шуудан” ХК 2017 онд 5 нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, 21 үнийн санал баримт бичиг боловсруулан харьцуулалтын аргаар худалдан авалт хийж, 2018 онд 7 нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, харьцуулалтын аргаар 8 тендер шалгаруулалт хийж, 2 зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлаж ажилласан байна.

Тус компанийн 2017-2018 оны худалдан авах ажиллагааг шалгахад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй 2017 онд 12.2 сая төгрөгийн, 2018 онд 90.5 сая төгрөгийн, **нийтдээ 102.7 сая төгрөгийн** худалдан авах ажиллагааны зөрчил, дутагдал гаргасан байна.

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл	Төсөвт өртөг /сая₮/	Гэрээний дүн /сая₮/	Бэлтгэн нийлүүлэгч	Мөрдсөн журам	Зөрчил, дутагдлын утга
2017 оны худалдан авалтын зөрчил						
1	Гадаад хэвлэл		12.2	Билгүүн засаг ХХК	ШГ	Хуулийн 33.1 дэх заалтыг зөрчсөн ХА хэрэглээгүй
2017 оны нийт дүн			12.2			
2018 оны худалдан авалтын зөрчил						
1	Зөвлөх үйлчилгээний төлбөр		30.72	Six sigma law limited	ШГ	Хуулийн 48.1, 8.1.2 дахь заалтыг зөрчсөн, төлөвлөгөөгүй, зөвлөх сонгох бага үнийн арга хэрэглээгүй
2	Маркийн хэвлэлтийн төлбөр		59.75	Cartor Security Printing	ШГ	Хуулийн 48.1 дэх заалтыг зөрчсөн төлөвлөгөөгүй
2018 оны нийт дүн		-	90.47			
2017-2018 оны нийт дүн		-	102.67			

- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т “шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 8.1.3-т “зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” гэж заасныг зөрчиж харьцуулалтын арга хэрэглээгүй, зөвлөх сонгон шалгаруулах арга хэрэглээгүй зэрэг худалдан авалт хийсэн.
- Хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 “Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийсэн.

Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг чанд мөрдөж, 2018 оны Сангийн сайдын 281 дүгээр тушаалаар баталсан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу маягтын хүрээнд төлөвлөгөө, тайланг бүрэн гүйцэд тайлагнаж байхыг анхааруулж байна.

Тав. Дүгнэлт, зөвлөмж цаашид авах арга хэмжээ

“Монгол Шуудан” ХК-ийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгээс үзэхэд: 2017 онд нийт 13,672.6 сая нийт төгрөгийн орлого олж, 12,321.0 сая төгрөгийн зардал гаргаж, 1,224.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 104.6 хувиар, зардлын төлөвлөгөөг 99.7 хувиар, цэвэр ашгийн төлөвлөгөөг 190.2 хувиар тус тус биелүүлж, 2018 онд нийт 15,474.0 сая нийт төгрөгийн орлого олж, 13,731.5 сая төгрөгийн зардал гаргаж, 1,560.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 107.5 хувиар, зардлын төлөвлөгөөг 100.2 хувиар, цэвэр ашгийн төлөвлөгөөг 254.9 хувиар тус тус биелүүлж ажилласан байна.

Тус компанийн удирдлага болон холбогдох ажиллагсад үндсэн үйл ажиллагааг найдвартай, хэвийн явуулах, шуудангийн борлуулалтыг нэмэгдүүлэн ашигтай ажиллах, шинэ зах зээлд гарч өрсөлдөх, шинээр салбар байгуулж хэрэглэгч, үйлчлүүлэгчид ойртох, маркетинг зар сурталчилгааг идэвхитэй явуулах зэрэг идэвх санаачлагатай нилээд ажил хийсэн байна.

Гэвч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 33, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж 102.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг зөрчил, дутагдал гаргасан байна.

Цаашид компанийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг арилгах, хөрөнгийн өгөөжийг сайжруулах, олон улсын болон дотоодын шуудан үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг чанд мөрдөж, 2018 оны Сангийн сайдын 281 дүгээр тушаалаар баталсан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу маягтын хүрээнд төлөвлөгөө, тайланг бүрэн гүйцэд тайлагнаж байх;
- Компанийн хөрөнгийг зохистой удирдаж авлага өглөгийг бууруулж ажиллах, нэг жилээс дээш хугацаатай авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;
- Анхан шатны баримт материалыг и баримтаар бүрдүүлж байх;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-д "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг баримтлаж төлбөрийн баримтыг цахим хэлбэрээр авч байх.

Төрийн өмчийн харилцааг зохицуулсан хууль, журмыг чандлан мөрдөх, тайланд дурдагдсан зөрчил, дутагдлыг давтан гаргаж байгаа явдлыг таслан зогсоохыг анхааруулж байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, компанийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолын төслийг боловсрууллаа.

ТАНИЛЦСАН:


ДЭД ДАРГА



А.ДАГВАДОРЖ

ХЯНАСАН:


ТӨБХХ-ИЙН ДАРГА,
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Ц.ТҮВШИНЗАЯА

ТӨБХХ-ИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

2019.10.18



Ө.БАТБААТАР


БОЛОВСРУУЛСАН:

ТӨБХХ-ИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН,
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



С.ЭНХЗОРИГ

ТӨБХХ-ИЙН БҮРТГЭЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



А.АЛТАНШАГАЙ


ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН: "МОНГОЛ ШУУДАН" ХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.АНХБААТАР

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



Б.НАРАНЦЭЦЭГ